

2023 он 06 сар 26 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

**Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай**

"Говь" ХК нь "Таван Богд Групп"-ийн толгой компани болох "Таван Богд Трейд" ХХК болон түүний охин компаниудтай хамтран авсан "ХААН" банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсгийг удирдлага болгон "Говь" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. "Таван Богд Трейд" ХХК түүний охин компаниуд болон "ХААН" банк нарын хооронд 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан ЗЭНГ17/48 тоот Зээлийн эрх нээх гэрээний хамтран зээлдэгчээс "Дата Бэйнк" ХХК-г хасч, "Бета Карс" ХХК болон "Таван Богд Нура" ХХК-иудыг хамтран зээлдэгчээр нэмэх, гэрээнд дараах Хөдөө Аж Ахуйн зээлийн нөхцөлүүдийг нэмэхийг зөвшөөрсүгэй.

Бүтээгдэхүүний нөхцөл	Валют	Дэд хэмжээ	Хүү	Хугацаа
Ноолуур бэлтгэлийн зээл	MNT	10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэл	18.0%	12 сар

\*Зээлийн хүү 18.0% бөгөөд Засгийн газраас 13.0%-ийн хүүний дэмжлэг үзүүлж зээлдэгч 5%-ийн хүү төлнө.

Хоёр. "Говь" ХК нь ЗЭНГ17/48 тоот Зээлийн эрх нээх гэрээний хүрээнд 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгийн дүнтэй, 5 (таван) хувийн хүүтэй, 12 (арван хоёр) сарын хугацаатай "Ноолуур бэлтгэлийн хөнгөлөлттэй зээл" авахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн зөвшөөрсүгэй.

Дөрөв. Зээлийн гэрээ, Барьцааны гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад "Говь" ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг тус компанийн Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д олгосугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ХАРААТ БУС ГИШҮҮД



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

Д.ХҮРЭЛБААТАР